

# ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ

2009 оны 07 сарын 16 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, хүн ам, нийгэм, байгаль орчныг ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл. Цөмийн энергийн тухай хууль тогтоомж

2.1. Цөмийн энергийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөрөнгө оруулалтын тухай, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

*/Энэ хэсэгт 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/  
/Энэ хэсэгт 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3. Цөмийн эрчим хүч ашиглахтай холбогдсон энэ хуулиар нарийвчлан зохицуулаагүй харилцааг Эрчим хүчний тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтаар зохицуулна.

### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “цөмийн энерги” гэж цөмийн хуваагдал болон цөмийн хувирлын дүнд үүссэн энергийг;

3.1.2. “цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах” гэж цөмийн энергийг цөмийн зэвсгээс бусад салбарт ашиглахыг;

3.1.3. “цөмийн болон цацрагийн аюулгүй байдал” гэж хүн ам, байгаль орчныг цацраг идэвхт бодис болон ионжуулагч цацрагийн бусад үүсгүүрийн нөлөөллөөс хамгаалах, цөмийн төхөөрөмж, цацрагийн үүсгүүрийн аюулгүй ажиллагааг хангасныг;

3.1.4. “цацраг идэвхт ашигт малтмал” гэж Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.2-т заасан уран болон торийн бүлийн цацраг идэвхт изотоп агуулсан эрдэс баялгийн хуримтлалыг;

3.1.5. “цөмийн бодис” гэж цөмийн материал болон цөмийн технологид хэрэглэгдэх уран, торийн бүлийн цацраг идэвхт изотоп, газрын ховор элемент агуулсан бодисыг;

3.1.6. “цөмийн төхөөрөмж” гэж цөмийн түлш бэлтгэх үйлдвэр, цөмийн болон судалгааны реактор, цөмийн эрчим хүчний эх үүсвэр, цөмийн түлш болон ашигласан түлш хадгалах байгууламж, баяжуулах үйлдвэр, ашигласан түлшийг дахин боловсруулах үйлдвэрийг;

3.1.7. “ионжуулагч цацраг” гэж шууд болон шууд бус замаар бодис, биологийн биет дотор хос ион үүсгэх цацрагийг;

3.1.8. “цөмийн эрчим хүчний нөөц” гэж Эрчим хүчний тухай хуулийн 3.1.21-д заасныг;

3.1.9.“цөмийн эрчим хүч” гэж Эрчим хүчний тухай хуулийн 3.1.22-т заасныг;  
3.1.10.“цөмийн эрчим хүчний эх үүсвэр” гэж Эрчим хүчний тухай хуулийн 3.1.23-т заасныг;

3.1.11.“цөмийн түлш” гэж цөмийн энерги гаргаж авахад хэрэглэгддэг материалыг;

3.1.12.“цөмийн материал” гэж цөмийн реактор болон цөмийн зэвсэгт ашиглагддаг материалыг;

3.1.13.“цацрагийн үүсгүүр” гэж цөмийн төхөөрөмжөөс бусад цацрагийн шарлага үүсгэгч цацраг идэвхт бодис болон ионжуулагч цацраг гаргагч аливаа багаж хэрэгслийг;

3.1.14.“цөмийн түлшний материал” гэж цөмийн хуваагдлын дүнд их хэмжээний энерги үүсгэх цөмийн бодисыг;

3.1.15.“цөмийн эх үүсвэр материал” гэж цөмийн түлшний материалыг гарган авах уран, торийн хүдэр, газрын ховор элемент зэрэг түүхий эд материалыг;

3.1.16.“цацраг идэвхт хаягдал” гэж цацраг идэвхийн хэмжээ нь хаягдлын стандартад заасан зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн, ямар ч төлөв байдалд байж болох, цаашид дахин хэрэглэгдэхгүй зүйлсийг;

3.1.17.“шар нунтаг” гэж ураны хүдрийг боловсруулах үйл ажиллагааны явцад завсрын шатанд үүсэх ураны ислийг;

3.1.18.“биет хамгаалалт” гэж Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай Венийн конвенцийн дагуу цөмийн материал болон цөмийн төхөөрөмж рүү зөвшөөрөлгүй этгээд нэвтрэн орохоос урьдчилан сэргийлсэн арга хэмжээ буюу зохион байгуулалтын нэгдсэн системийг;

3.1.19.“шарлага” гэж цацраг идэвхт бодис, ионжуулагч цацрагийн үүсгүүрээс хүнд үзүүлэх нөлөөллийг;

3.1.20.“мэргэжлийн шарлага” гэж ажлын нөхцөлийн улмаас цацрагтай ажиллагчийн өртөж байгаа аливаа цацрагийн нөлөөллийг;

3.1.21.“тун” гэж ионжуулагч цацрагаас бие махбодид шингээгдсэн энергийн хэмжээгээр тодорхойлогддог цацрагийн шарлагыг илэрхийлэх хэмжигдэхүүнийг;

3.1.22.“цацраг идэвхт хаягдал булшлах” гэж зөвхөн өөрийн орны цацраг идэвхт хаягдлыг булшлахыг.

#### **4 дүгээр зүйл.Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах үйл ажиллагаанд баримтлах зарчим**

4.1.Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

4.1.1.Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд харшлахгүй байх;

4.1.2.Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн байх;

4.1.3.олон улсын гэрээнд заасны дагуу зөвхөн энхийн зорилгоор явуулах;

4.1.4.олон улсын болон үндэсний стандартыг чанд мөрдөх;

4.1.5.хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюулгүй техник, технологи ашиглах.

#### **5 дугаар зүйл.Цацраг идэвхт ашигт малтмалын өмчлөл болон цацраг идэвхт ашигт малтмал ашиглах үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоо**

5.1.Монгол Улсын газрын хэвлийд оршиж байгаа цацраг идэвхт ашигт малтмал төрийн өмч мөн.

5.2.Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон цацраг идэвхт ашигт малтмалын ордыг бусадтай хамтран ашиглах тохиолдолд түүнтэй хамтран байгуулах компанийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ.

5.3.Улсын төсвийн хөрөнгийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн орд газарт цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцааны 34-өөс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ.

5.4.Энэ хуулийн 5.2, 5.3-т зааснаас илүү хувиар төр хувьцаа эзэмших тохиолдолд уг хувийг төрөөс оруулсан буюу оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.

## **6 дугаар зүйл. Цацраг идэвхт ашигт малтмалын ордын ангилал**

6.1.Цацраг идэвхт ашигт малтмалын ордыг хэмжээнээс нь үл хамааран стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ангилалд хамааруулна.

## **7 дугаар зүйл. Засгийн газрын онцгой бүрэн эрх**

7.1.Энэ хуулийн 15.1.2, 15.2.1, 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон хувьцаа эзэмшигч нь дараах асуудлаар шийдвэр гаргахаас өмнө Цөмийн энергийн комиссоос зөвшөөрөл авна:

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

7.1.1.тухайн компанийн хувьцааны 5-аас дээш хувийг худалдах, бэлэглэх, барьцаалах болон өөр бусад хэлбэрээр бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлэх;

7.1.2.тухайн компанийн хувьд хувьцаа авах эрхийн бичиг буюу хувьцаанд хөрвөх үнэт цаас шинээр гаргах, эсхүл урьд гаргасан нийт хувьцааны 5 хувиас дээш хэмжээний хувьцаа нэмж гаргах;

7.1.3.тухайн компанийг нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулах.

7.2.Энэ хуулийн 15.1.2, 15.2.1, 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мөн хуулийн 7.1-д заасан шийдвэрийг гаргаснаас хойш 14 хоногийн дотор дараахь баримт бичгийг Цөмийн энергийн комисст хүргүүлнэ:

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

7.2.1.энэ хуулийн 7.1.1-д заасан шийдвэрийн албан ёсны эх хувь, хувьцааг өмчлөл, эзэмшил, ашиглалтдаа авах этгээдийн нэр, хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл болон уг шийдвэртэй холбоотой Цөмийн энергийн комиссоос шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл;

7.2.2.энэ хуулийн 7.1.2-т заасан шийдвэрийн албан ёсны эх хувь, хувьцаа, хувьцаа авах эрхийн бичиг буюу хувьцаанд хөрвөх үнэт цаасыг худалдан авах этгээдийн нэр, хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл болон уг шийдвэртэй холбоотой Цөмийн энергийн комиссоос шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл;

7.2.3.энэ хуулийн 7.1.3-т заасан шийдвэрийн албан ёсны эх хувь, компанийг өөрчлөн байгуулах төлөвлөгөө болон уг шийдвэртэй холбоотой Цөмийн энергийн комиссоос шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

7.3.Цөмийн энергийн комисс энэ хуулийн 7.2-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор тухайн шийдвэрийг батламжлах, эс батламжлах шийдвэрийн аль нэгийг гаргана.

7.4.Энэ хуулийн 15.1.2, 15.2.1, 15.2.2-т заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч мөн хуулийн 7.1, 7.2-т заасан үүргийг биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл олгосон байгууллага нь тухайн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

**ХОЁРДУГААР БҮЛЭГ**  
**ЦАЦРАГ ИДЭВХТ АШИГТ МАЛТМАЛ БОЛОН ЦӨМИЙН ЭНЕРГИ**  
**АШИГЛАХ САЛБАР ДАХЬ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

**8 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх**

8.1.Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн асуудлаар Улсын Их Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах талаар төрөөс баримтлах бодлогыг батлах;

8.1.2.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас зохион байгуулж байгаа ажилд хяналт тавих;

8.1.3.төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зардлыг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх.

**9 дүгээр зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

9.1.Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн асуудлаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах;

9.1.2.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

9.1.3.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан Олон улсын атомын энергийн агентлагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

9.1.4.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах талаар нийтлэг дүрэм, журам, зааврыг батлах;

9.1.5.нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, ослын үр дагаврыг арилгах, ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах;

9.1.6.нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан тохиолдолд түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах арга хэмжээ авах;

9.1.7.цөмийн төхөөрөмж барих газрын байршлыг сонгох;

9.1.8.цөмийн хаягдал, ашиглагдсан цөмийн түлшийг хүн ам, нийгэм, байгаль орчинд аюулгүй хадгалах урт хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.

**10 дугаар зүйл. Цөмийн энергийн комисс**

10.1.Улсын хэмжээнд цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, судалгааг хөгжүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий Цөмийн энергийн комисс (цаашид “Комисс” гэх) ажиллана.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

10.2.Комиссын дарга нь Ерөнхий сайд байна.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

10.3.Комиссын бүрэлдэхүүн, үйл ажиллагааны дүрмийг Засгийн газар батална.

10.4.Комисс нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

10.5.Цөмийн энергийн комисс ажлын албатай байна.

*/Энэ хэсгийг 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмсэн/*

10.6.Ажлын албаны дарга бөгөөд Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн даргыг Монгол Улсын Ерөнхий сайд томилж, чөлөөлнө.

*/Энэ хэсгийг 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмсэн/*

## **11 дүгээр зүйл.Цөмийн энергийн комиссын бүрэн эрх**

11.1.Цөмийн энергийн комисс дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

11.1.2.энэ хуулийн 28.8-д заасан мэдээллийг нэгтгэн боловсруулж, шаардлагатай бол магадлан шалгаж Олон улсын атомын энергийн агентлагт зохих журмын дагуу хүргүүлэх;

11.1.3.цөмийн материалын тооллого, алдагдал, хорогдол, шилжилт хөдөлгөөн хийх журмыг батлах;

11.1.4.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон нийтлэг дүрэм, журмыг батлах;

11.1.5.гадаад улс, олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн дагуу хамтран ажиллах;

11.1.6.ураны баяжмал, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийн онцлогийг харгалзан түүний хүчин чадал, тоо хэмжээ, шилжилт хөдөлгөөн, тээвэрлэлтийн холбогдолтой нууцлах мэдээллийн жагсаалтыг баталж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах;

11.1.7.цөмийн болон цацраг идэвхт хаягдал, цацрагийн үүсгүүрийг улсын хэмжээнд төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

11.1.8.улсын хэмжээнд ашиглаж байгаа ионжуулагч цацраг бүртгэх багаж, тоног төхөөрөмжийн хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, тохируулга хийх;

11.1.9.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

11.2.Цөмийн энергийн комисс нь цөмийн материал, цөмийн болон ашиглагдахгүй болсон цацраг идэвхт хаягдлыг улсын хэмжээнд төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх, булшлах тусгай байгууламжтай байх бөгөөд уг байгууламж нь улсын онц чухал объект байна.

11.3.“Цөмийн болон ашиглагдахгүй болсон цацраг идэвхт хаягдал” гэж цөмийн төхөөрөмжөөс гарах цацраг идэвхт хаягдлаас бусад төрлийн цөмийн технологийн хэрэглээний хаягдлыг ойлгоно.

*/Энэ зүйлийг 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

## **11№ дүгээр зүйл.Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх**

11<sup>1</sup>.1.Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11<sup>1</sup>.1.1.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

11<sup>1</sup>.1.2.цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон нийтлэг дүрэм, журам, заавар, стандартыг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

11<sup>1</sup>.1.3.цөмийн болон цацрагийн болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, ослын үр дагаврыг арилгах, ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг мэргэжлийн холбогдох байгууллагатай хамтран боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

11<sup>1</sup>.1.4.хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, баримт бичгийг холбогдох этгээдээс үнэ төлбөргүй гаргуулж авах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллага, мэргэжилтнийг хяналт шалгалтад татан оролцуулах;

11<sup>1</sup>.1.5.цөмийн материал, цацрагийн үүсгүүрийн улсын бүртгэл хөтөлж, цацрагтай ажиллагчийн өртөж байгаа мэргэжлийн шарлагын тунд хяналт тавих, шарлагын тунгийн мэдээллийн сан бүрдүүлэх;

11<sup>1</sup>.1.6.үйлдвэрлэл, судалгаа, оношилгоо, эмчилгээнд хэрэглэж байгаа цацрагийн үүсгүүр бүхий тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавих;

11<sup>1</sup>.1.7.улсын хилээр нэвтрүүлэх цөмийн материал, цацрагийн үүсгүүр бүхий багаж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлд холбогдох байгууллагатай хамтран хяналт тавьж, хамгаалалт, аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авах;

11<sup>1</sup>.1.8.хүрээлэн байгаа орчны болон ахуйн хэрэглээний бараа, материал, хүнсний бүтээгдэхүүн, ундны ус, барилгын материалын цацрагийн түвшний хяналт шинжилгээ хийх, тэдгээр нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэхийг тогтоох ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэх, чанарын баталгаажилтыг хангах арга хэмжээ авах;

11<sup>1</sup>.1.9.хуулиар хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай тохиолдолд холбогдох олон улсын байгууллагаас мэргэжлийн туслалцаа, дэмжлэг авах;

11<sup>1</sup>.1.10.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

*/Энэ зүйлийг 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмсэн/*

## **11<sup>2</sup> дугаар зүйл.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх**

11<sup>2</sup>.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11<sup>2</sup>.1.1.цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

11<sup>2</sup>.1.2.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

11<sup>2</sup>.2.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

энэ хуулийн 15.2.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан хайгуулын тайлан, техник, эдийн засгийн үндэслэл, энэ хуулийн 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан уурхайн ашиглалтын мэдээ, техник, эдийн засгийн үндэслэлийг түүний хүсэлтээр тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаанд нууцад хамааруулна.

11<sup>2</sup>.3. Энэ хуулийн 112.2-т заасны дагуу нууцад хамааруулсан мэдээллийг Төрийн нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хуульд заасан үндэслэл, журмаас гадуур задруулах, нийтлэх буюу нийтэд мэдээлэхийг хориглоно.

*/Энэ зүйлийг 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмсэн/*

*/2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар энэ хэсгийн “Төрийн нууцын тухай” гэснийг “Төрийн болон албаны нууцын тухай” гэж өөрчлөхөөр заасан бөгөөд 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/*

## **12 дугаар зүйл. Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч, түүний бүрэн эрх**

12.1. Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад цөмийн болон цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

12.2. Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно.

12.3. Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагч нь улсын ахлах байцаагч, улсын байцаагч (цаашид “улсын байцаагч” гэх)-ийг томилж, чөлөөлнө.

12.4. Улсын байцаагч цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлээр Төрийн хяналт шалгалтын тухай, Захиргааны хариуцлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

12.5. Улсын байцаагч хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын нөлөөнд үл автан гагцхүү хууль тогтоомж болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг удирдлага болгон ажиллана.

12.6. Улсын байцаагч хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

12.7. Улсын байцаагч хяналт шалгалт хийх цөмийн төхөөрөмж болон холбогдох бусад объектод саадгүй нэвтэрнэ.

12.8. Улсын байцаагчийн хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхэд хамаарах аливаа асуудлаар бусад этгээд шийдвэр гаргахыг хориглоно.

12.9. Цөмийн болон цацрагийн хяналт шалгалтыг улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу хийнэ.

12.10. Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч, цацрагтай ажиллагч нь ажлын онцлогт тохирсон тусгай хувцас, ялгах тэмдэг хэрэглэх бөгөөд ажлын тусгай хувцасны загвар, хэрэглэх журам, эдэлгээний хугацааг Цөмийн энергийн комисс батална.

*/Энэ хэсгийг 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмсэн/*

### **13 дугаар зүйл.Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх**

13.1.Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн асуудлаар нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1.цөмийн энергийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

13.1.2.харьяалах нутаг дэвсгэрт нь тусгай зөвшөөрөл олгогдсон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын талбайг зориулалтын дагуу ашиглуулах, гарсан зөрчлийг таслан зогсоох;

13.1.3.тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;

13.1.4.цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх талаар харьяалах нутаг дэвсгэртээ сургалт, сурталчилгаа зохион байгуулах.

### **14 дүгээр зүйл.Хил хамгаалах болон гаалийн байгууллага, түүний албан тушаалтны бүрэн эрх**

14.1.Хил хамгаалах болон гаалийн байгууллага, түүний албан тушаалтан хяналт шалгалтаар илэрсэн, зохих зөвшөөрөлгүй цөмийн материал, цацрагийн үүсгүүр, цацрагийн үүсгүүртэй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн талаар мэргэжлийн хяналтын болон хууль хяналтын байгууллагад нэн даруй мэдэгдэж, аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авна.

*/Энэ зүйлийг 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ**

### **15 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл**

15.1.Дараах үйл ажиллагааг Цөмийн энергийн комиссоос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ:

15.1.1.цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах;

15.1.2.цөмийн төхөөрөмж ашиглах;

15.1.3.цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах;

15.1.4.цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах.

15.2.Дараах үйл ажиллагааг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ:

15.2.1.цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх;

15.2.2.цацраг идэвхт ашигт малтмал ашиглах;

15.2.3.цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах болон цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх.

15.3.Дараах үйл ажиллагааг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ:

15.3.1.цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах;

15.3.2.цацрагийн үүсгүүрийг угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах;

15.3.3.цацрагийн үүсгүүрийг тээвэрлэх, импортлох, экспортлох;

15.3.4.цацрагийн үүсгүүрийн хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа.

*/Энэ зүйлийг 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

## **16 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих ерөнхий шаардлага**

16.1.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, тус улсад татвар төлөгч компанид олгож болно.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

16.2.Энэ хуулийн 15.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 16.1-д заасан компаниас гадна бусад шаардлагатай аж ахуйн нэгж, байгууллагад олгож болно.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

16.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь ерөнхий шаардлагыг биелүүлнэ:

16.3.1.үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын болон үндэсний стандартыг дагаж мөрдөх;

16.3.2.үйл ажиллагаандаа хүний эрүүл мэндэд аюулгүй, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи ашиглах;

16.3.3.үйл ажиллагаа нь ил тод, тогтвортой байх;

16.3.4.болзошгүй ослын хохирлыг арилгах санхүү, эдийн засгийн чадавхитай байх.

## **17 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл хүсэгчид тавих шаардлага**

17.1.Энэ хуулийн 15.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч дараахь нөхцөлийг хангасан байна:

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

17.1.1.техникийн болон аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байх;

17.1.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг бүрэн хангасан байх;

17.1.3.бүс нутгийн хөгжил, эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд санаачлагатай оролцдог байх;

17.1.4.компанийн засаглал болон нийгмийн хариуцлага, ёс зүйн талаархи дэлхий нийтэд хүлээн зөвшөөрсөн стандартыг хэвшүүлсэн байх;

17.1.5.үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй байх;

17.1.6.ажиллагсдын сургалт, дадлагын асуудлыг шийдэж ирсэн туршлагатай байх.

17.2.Энэ хуулийн 15.2.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч мөн хуулийн 17.1-д зааснаас гадна дараахь нөхцөлийг хангасан байна:

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

17.2.1.цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх санхүүгийн чадавхитай байх;

17.2.2.байгаль орчны болон биологийн нөхөн сэргээлт хийх санхүүгийн чадавхитай байх;

17.2.3.хариуцлагатай уул уурхайг хөтлөн явуулдаг, энэ талаар зохих туршлага хуримтлуулсан байх;

17.2.4.уул уурхайн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны олон улсын стандарт, шаардлагыг хангаж ажилладаг байх.

17.3.Энэ хуулийн 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч мөн хуулийн 17.1-д зааснаас гадна дараахь нөхцөлийг хангасан байна:

*/Энэ хэсэгт 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

17.3.1.энэ хуулийн 17.2.1-17.2.4-т заасан нөхцөлийг хангасан байх;

17.3.2.цацраг идэвхт ашигт малтмалыг энхийн зорилгоор, дэлхийн зах зээлийн үнэд хүргэж борлуулах чадвартай, санхүүгийн хувьд бүрэн бие даасан байх;

17.3.3.цацраг идэвхт ашигт малтмалын боловсруулалт, борлуулалтаар дэлхийн зах зээлд тогтвортой, тэргүүлэх байр суурь эзэлсэн байх;

17.3.4.цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт хийх санхүүгийн чадавхитай байх;

17.3.5.цацраг идэвхт ашигт малтмал олборлох, боловсруулах олон жилийн туршлагатай байх;

17.3.6.цацраг идэвхт ашигт малтмалын ордын нөөцийг бүрэн ашиглах тэргүүний технологитой байх;

17.3.7.цацраг идэвхт ашигт малтмалыг боловсруулах, ашиглахдаа эдийн засгийн илүү үр ашигтай, дэвшилтэт технологи ашигладаг байх;

17.3.8.цөмийн технологи нэвтрүүлэх чадвартай байх.

17.4.Энэ хуулийн 15.2.3, 15.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч мөн хуулийн 17.1.1, 17.1.2, 17.1.4, 17.1.5-д заасан нөхцөлийг хангасан байна.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

## **18 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох журам**

18.1.Энэ хуулийн 15.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг мөн хуулийн 17.1-д заасан нөхцөлийг хамгийн сайн хангасан тусгай зөвшөөрөл хүсэгчид олгоно.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

18.2.Энэ хуулийн 15.2.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг мөн хуулийн 17.2-т заасан нөхцөлийг хамгийн сайн хангасан бөгөөд энэ хуулийн 5.2 буюу 5.3-т заасан нөхцөлийг зөвшөөрсөн тусгай зөвшөөрөл хүсэгчид олгоно.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

18.3.Энэ хуулийн 18.5-д зааснаас бусад тохиолдолд мөн хуулийн 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 17.3-т заасан нөхцөлийг хамгийн сайн хангасан бөгөөд энэ хуулийн 5.2 буюу 5.3-т заасан нөхцөлийг зөвшөөрсөн тусгай зөвшөөрөл хүсэгчид олгоно.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

18.4.Энэ хуулийн 15.2.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг мөн хуулийн 17.4-т заасан нөхцөлийг хамгийн сайн хангасан тусгай зөвшөөрөл хүсэгчид олгоно.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

18.5.Энэ хуулийн 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараахь тохиолдолд давуу эрхээр олгож болно:

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

18.5.1.энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан бөгөөд мөн хуулийн 5.2 буюу 5.3-т заасан нөхцөлийг зөвшөөрсөн цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн хөрөнгөөр хайгуулын ажил хийж, нөөцийг нь тогтоон, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн хайгуулын талбайд цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан бол;

18.5.2.тухайн уурхайн цацраг идэвхт ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн нөөцийн 10 хувиас багагүй хэмжээтэй тэнцэх мөнгөн төлбөрийг улсын төсөвт нэг удаа, шууд төлөхийг зөвшөөрсөн тусгай зөвшөөрөл хүсэгч нь энэ хуулийн 18.5.1-д зааснаас бусад хайгуулын талбайд цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан бол.

18.6.Энэ хуулийн 18.5.2-т заасан тусгай зөвшөөрөл хүсэгч нь мөн хуулийн 17.3-т заасан нөхцөлийг хангасан бөгөөд энэ хуулийн 5.2 буюу 5.3-т заасан нөхцөлийг зөвшөөрсөн байна.

18.7.Энэ хуулийн 18.5.2-т заасан мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо цацраг идэвхт ашигт малтмалын олон улсын зах зээлийн үнийн сүүлийн 6 сарын дундаж ханшийг харгалзан тогтооно.

18.8.Энэ хуулийн 15.1.1-15.1.4-т заасан үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тагнуулын төв байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас, энэ хуулийн 15.2-т заасан үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход Цөмийн энергийн комисс, тагнуулын төв байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас, энэ хуулийн 15.3-т заасан тусгай зөвшөөрөл олгоход Цөмийн энергийн комиссоос тус тус санал авсан байна.

*/Энэ хэсгийг 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

18.9.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг хянан үзээд тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг үйл ажиллагааны онцлогийг харгалзан энэ хуулийн 15.1, 15.2.2, 15.2.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 6-12 сар, энэ хуулийн 15.2.1, 15.3.1, 15.3.2, 15.3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 1-3 сарын дотор, энэ хуулийн 15.3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3-14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

*/Энэ хэсгийг 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

18.10.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд үндэслэлийг зааж бичгээр хариу өгнө.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

18.11.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага шаардлагатай бол өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэх эрхтэй.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

## **19 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах журам**

19.1.Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.1-11.1.3-т зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

19.1.1.эрхлэх үйл ажиллагааны зорилго, төрөл, үндсэн чиглэл, техник, эдийн засгийн үндэслэл, мэргэжлийн боловсон хүчний танилцуулга, дотоод хяналтын ажилтан болон цацрагтай ажиллагчийн мэргэшлийн бэлтгэл, сургалтын гэрчилгээ;

19.1.2.эрхлэх үйл ажиллагаанд холбогдох аюулгүй ажиллагааны олон улсын стандартын шаардлагад нийцсэн иж бүрэн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө;

19.1.3.үйл ажиллагаа эрхлэх байрны цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүйн стандартын шаардлага хангасан талаархи төрийн захиргааны байгууллагын үнэлгээ;

19.1.4.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

19.1.5.байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө;

19.1.6.цөмийн болон цацрагийн болзошгүй ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө;

19.1.7.цөмийн болон цацрагийн аюулгүй байдалд дотоодын хяналт тавих алба, эсхүл хариуцсан ажилтныг томилсон тухай шийдвэр;

19.1.8.болзошгүй цөмийн болон цацрагийн осол, сүйрлийн хор уршгийг арилгахад шаардлагатай нөөц боломж, хүч хэрэгслийн тухай танилцуулга;

19.1.9.цацрагийн хэмжилтийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн гэрчилгээ, үндсэн үзүүлэлт.

19.2.Энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь мөн хуулийн 19.1-д зааснаас гадна Эрчим хүчний тухай хуулийн 21.2-т заасан баримт бичгийг бүрдүүлэн, эрхлэх үйл ажиллагаанд шаардлагатай кадастрын зураглалыг хавсаргана.

19.3.Энэ хуулийн 15.2.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь мөн хуулийн 19.1-д зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

19.3.1.энэ хуулийн 5.2 буюу 5.3-т заасан нөхцөлийг зөвшөөрснөө нотолсон албан ёсны шийдвэр;

19.3.2.Ашигт малтмалын тухай хуулийн 18.2-т заасан баримт бичиг.

19.4.Энэ хуулийн 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь мөн хуулийн 19.1-д зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

19.4.1.энэ хуулийн 19.3.1-д заасан шийдвэр;

19.4.2.Ашигт малтмалын тухай хуулийн 25.1-д заасан баримт бичиг.

19.5.Энэ хуулийн 15.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь мөн хуулийн 19.1-д зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

19.5.1.ашиглах цацрагийн үүсгүүр, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үйлдвэрийн гэрчилгээ, үндсэн үзүүлэлтүүд;

19.5.2.цацрагийн үүсгүүрийн чанарын баталгаажилтын гэрчилгээ.

19.6.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь өргөдлийг хүлээн аваад дараахь ажиллагааг явуулна:

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

19.6.1.өргөдлийг бүртгэж, энэ тухай тодорхойлолтыг өргөдөл гаргасан этгээдэд өгөх;

19.6.2.өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянах.

19.7.Энэ хуулийн 15.2.1, 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн хувьд ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 19.6-д заасан ажиллагаанаас гадна Ашигт малтмалын тухай хуулийн 26.2-т заасан ажиллагааг явуулна.

*/Энэ хэсгийг 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

19.8.Тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллага нь энэ тухай ажлын таван өдөрт багтаан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Цөмийн энергийн комисс, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллага, олон нийтэд тус тус мэдээлнэ.

*/Энэ хэсгийг 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

## **20 дугаар зүйл.Төлбөр, хураамж**

20.1.Энэ хуулийн 15.1.1-15.1.4, 15.1.7, 15.1.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн 15.7-д заасны дагуу улсын тэмдэгтийн хураамж төлнө.

20.2.Энэ хуулийн 15.2.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 32.2-т заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр төлнө.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

20.3.Энэ хуулийн 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь төлбөрийг төлнө:

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

20.3.1.Ашигт малтмалын тухай хуулийн 32.3-т заасны дагуу ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр;

20.3.2.Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр.

20.4.Энэ хуулийн 20.2, 20.3.1-д заасан тусгай зөвшөөрлийн төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан журмын дагуу төлнө.

20.5.Энэ хуулийн 20.2, 20.3.1-д заасан тусгай зөвшөөрлийн төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу хуваарилна.

20.6.Энэ хуулийн 20.3.2-т заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хуваарилна.

## **21 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийн хугацаа**

21.1.Энэ хуулийн 15.1.1, 15.1.3, 15.1.4, 15.2.1, 15.2.3, 15.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тухайн үйл ажиллагааны онцлог, хяналт шалгалтын үр дүнг харгалзан 3 жил хүртэл хугацаагаар олгоно.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

21.2.Энэ хуулийн 15.1.2, 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг техник, эдийн засгийн үндэслэл, хяналт шалгалтын үр дүнг харгалзан 20 жил хүртэл хугацаагаар олгоно.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

## **22 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах**

22.1.Энэ хуулийн 15.1.1, 15.1.3, 15.1.4, 15.2.1, 15.2.3, 15.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 1-ээс доошгүй сарын өмнө түүний хугацааг сунгуулах тухай өргөдлийг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад гаргаж болно.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

22.2.Энэ хуулийн 15.1.2, 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 2-оос доошгүй жилийн өмнө түүний хугацааг сунгуулах тухай өргөдлийг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад гаргаж болно.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

22.3.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага энэ хуулийн 22.1-д заасан өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 30 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мөн хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан эсэхийг хянан, зөрчилгүй бол үйл ажиллагааны онцлогийг харгалзан тусгай зөвшөөрлийг 3 жил хүртэл хугацаагаар сунгаж, энэ тухай тусгай зөвшөөрлийн бүртгэлд тэмдэглэнэ.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

22.4.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага энэ хуулийн 22.2-т заасан өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 60 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мөн хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан эсэхийг хянан, зөрчилгүй бол үйл ажиллагааны онцлогийг харгалзан тусгай зөвшөөрлийг 20 жил хүртэл хугацаагаар сунгаж, энэ тухай тусгай зөвшөөрлийн бүртгэлд тэмдэглэнэ.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

22.5.Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах өргөдөлд дараахь баримт бичгийг хавсаргана:

22.5.1.тусгай зөвшөөрлийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

22.5.2.улсын тэмдэгтийн хураамж, эсхүл тусгай зөвшөөрлийн төлбөр төлсөн баримт;

22.5.3.энэ хуулийн 15.2.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах өргөдлийн хувьд Ашигт малтмалын тухай хуулийн 22.1.1-22.1.4-т заасан баримт бичиг;

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

22.5.4.энэ хуулийн 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах өргөдлийн хувьд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хянасан тухай баримт.

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

22.6.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан шийдвэрийг ажлын 5 өдөрт багтаан энэ хуулийн 19.8-д заасан байгууллага болон олон нийтэд мэдээлнэ.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

### **23 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх**

23.1.Тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу түдгэлзүүлнэ.

### **24 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрөл шилжүүлэхийг хориглох**

24.1.Тусгай зөвшөөрөл болон энэ хуулийн 15.2.1, 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг худалдах, бэлэглэх, барьцаалах болон өөр бусад хэлбэрээр бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлэхийг хориглоно.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

### **25 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөлтэй холбогдсон маргааныг шийдвэрлэх**

25.1.Энэ хуулийн 15.2.1, 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд үүссэн талбайн хилийн маргааныг Ашигт малтмалын тухай хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

25.2.Энэ хуулийн 15.2.1, 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч болон газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хооронд гарсан маргааныг Ашигт малтмалын тухай хуулийн 63 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

### **26 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох**

26.1.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага энэ хуулийн 15.1, 15.2.3, 15.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараахь үндэслэлээр хүчингүй болгоно:

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

26.1.1.компани татан буугдсан, эсхүл иргэн нас барсан;

26.1.2.тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

26.1.3.тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

26.1.4.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

26.2.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага энэ хуулийн 15.2.1, 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараахь үндэслэлээр хүчингүй болгоно:

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

26.2.1.энэ хуулийн 26.1-д заасан үндэслэл бий болсон;

26.2.2.Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.3-56.1.5-д заасан үндэслэл бий болсон;

26.2.3.энэ хуулийн 15.2.1, 15.2.2-т заасан тусгай зөвшөөрлийн хувьд мөн хуулийн 29.4-т заасан үндэслэл бий болсон.

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

26.3.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл тогтоогдсоноос хойш ажлын 10 өдрийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигчид энэ тухай мэдэгдэл өгөх бөгөөд түүнд тусгай зөвшөөрөл хүчингүй болгох үндэслэлийг тодорхой заана.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

26.4.Энэ хуулийн 26.3-т заасан тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэлийг зөвшөөрөхгүй бол тусгай зөвшөөрөл эзэмшигч түүнийгээ нотлох баримт бичгийг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад ирүүлнэ.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

26.5.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага энэ хуулийн 26.4-т заасан нотлох баримт бичгийг хянаж үндэслэлтэй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай мэдэгдлийг хүчингүй болгох ба үндэслэлгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, энэ тухай шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэнэ.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

26.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 26.5-д заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй бөгөөд шүүх тухайн шийдвэрийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62.1.3-т заасны дагуу түдгэлзүүлж болохгүй.

*/Энэ хэсэгт 2016 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

26.7.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг ажлын 5 өдөрт багтаан энэ хуулийн 19.8-д заасан байгууллага болон олон нийтэд мэдээлнэ.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

## **27 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл дуусгавар болох үндэслэл**

27.1.Тусгай зөвшөөрөл дараахь үндэслэлээр дуусгавар болно:

27.1.1.тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан;

27.1.2.энэ хуулийн 15.2.1, 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь буцаан өгсөн;

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

27.1.3. тусгай зөвшөөрөл олгосон байгууллага тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

27.2. Энэ хуулийн 15.2.1, 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн тодорхой хэсгийг буцаан өгсөн тохиолдолд талбайн тухайн хэсгийн хувьд тусгай зөвшөөрөл нь дуусгавар болно.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

27.3. Тусгай зөвшөөрөл дуусгавар болсноор тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу хүлээх үүргээс чөлөөлөгдөхгүй.

27.4. Тусгай зөвшөөрөл дуусгавар болоход түүнийг эзэмшиж байсан этгээд тусгай зөвшөөрлийг тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад буцааж өгнө.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

## **28 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг**

28.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь нийтлэг эрхтэй:

28.1.1. цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах асуудлаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;

28.1.2. хууль тогтоомжид заасан бусад эрх.

28.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь нийтлэг үүрэгтэй:

28.2.1. цөмийн энергийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэр, дүрэм, журам, заавар, стандартыг мөрдөх;

28.2.2. Олон улсын атомын энергийн агентлагаас тогтоосон техникийн болон аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан үйл ажиллагаа явуулах;

28.2.3. цөмийн болон цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангаж ажиллах;

28.2.4. эрх бүхий байгууллага, улсын байцаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг хугацаанд нь биелүүлж хариу мэдэгдэх, илэрсэн зөрчлийг бүрэн арилгах арга хэмжээ авах;

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

28.2.5. цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий дотоод хяналтын нэгж байгуулан, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

28.2.6. мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар батлуулсан цөмийн болон цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрмийг мөрдөж ажиллах;

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

28.2.7. цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий ажилтан солигдсон тохиолдолд энэ талаар мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ажлын 3 өдрийн дотор бичгээр мэдэгдэх;

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

28.2.8.цөмийн материалын бүртгэл, хяналтын талаархи үнэн, бодит мэдээллийг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад өгөх;

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

28.2.9.цацрагийн түвшний тухай мэдээллийг төрийн захиргааны байгууллагын шаардсанаар тухай бүр гаргаж өгөх;

28.2.10.тусгай зөвшөөрөл болон түүнийг авахад бүрдүүлсэн материалд заасан аливаа мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд энэ талаар ажлын 5 өдрийн дотор тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад бичгээр мэдэгдэх;

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

28.2.11.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

28.3.Энэ хуулийн 15.2.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мөн хуулийн 28.1-д зааснаас гадна дараахь эрхтэй:

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

28.3.1.хайгуулын талбайн хилийн дотор энэ хуулийн дагуу цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх.

28.4.Энэ хуулийн 15.2.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мөн хуулийн 28.2-т зааснаас гадна дараахь үүрэгтэй:

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

28.4.1.хайгуулын талбайн хилийн дотор цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрэх, хайх;

*/Энэ заалтыг 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

28.4.2.Ашигт малтмалын тухай хуулийн 33.1-д заасан хэмжээнээс багагүй зардал бүхий хайгуулын ажлыг жил бүр хийж гүйцэтгэх;

28.4.3.Ашигт малтмалын тухай хуулийн 35.2, 37.2, 38.1, 48.8-т заасан үүргийг биелүүлэх;

28.4.4.Ашигт малтмалын тухай хуулийн 48.1-д заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргаж геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

28.4.5.Ашигт малтмалын тухай хуулийн 48.3-т заасны дагуу ордын нөөц, эрэл, хайгуулын үр дүнгийн нэгдсэн тайланг батлагдсан маягт, шаардлагад нийцүүлэн боловсруулж, анхдагч материалын хамт геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх.

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

28.5.Энэ хуулийн 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мөн хуулийн 28.1-д зааснаас гадна дараахь эрхтэй:

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

28.5.1.уурхайн талбайд цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул явуулах.

28.6.Энэ хуулийн 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мөн хуулийн 28.2-т зааснаас гадна дараахь үүрэгтэй:

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

28.6.1. тухайн уурхайн эдэлбэрт оршиж байгаа цацраг идэвхт ашигт малтмалыг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу ашиглах;

~~28.6.2. тухайн уурхайн эдэлбэрт оршиж байгаа цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглах;~~

~~*/Энэ заалтыг 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*~~

28.6.3. уурхайн эдэлбэрээс олборлосон цацраг идэвхт ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн үнээр борлуулах;

28.6.4. Ашигт малтмалын тухай хуулийн 35.3-35.5, 36.1, 36.2, 39.1, 45.1, 45.2, 47.1, 47.5, 47.6, 48.7-48.10-т заасан үүргийг биелүүлэх;

28.6.5. Ашигт малтмалын тухай хуулийн 48.6-д заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг батлагдсан маягтын дагуу хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргаж геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

28.7. Энэ хуулийн 15.1.5, 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 54, 55 дугаар зүйлд заасан журмын дагуу өөрийн хүсэлтээр тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, хяналтын дор бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн буцаан өгч болох бөгөөд хүсэлт гаргах өргөдлийн маягтыг төрийн захиргааны байгууллага батална.

~~*/Энэ хэсгийг 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*~~

28.8. Баталгааны гэрээнд холбогдох тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цөмийн материалын тоо, хэмжээ, түүнд орсон өөрчлөлт, алдагдал, хорогдол, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой мэдээллийг зааврын дагуу тогтоосон хугацаанд Цөмийн энергийн комисст үнэн зөвөөр гаргаж өгөх үүрэгтэй.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

28.9. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх үүргээ биелүүлэх баталгаа болгон Төрийн санд мөнгөн хөрөнгө байршуулна.

28.10. Энэ хуулийн 28.9-д заасан мөнгөн хөрөнгийн хэмжээг нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд учирч болох эрсдлийг харгалзан геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, байгаль орчны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтран гаргасан саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ОРД АШИГЛАХ ГЭРЭЭ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ**

### **29 дүгээр зүйл.Орд ашиглах гэрээ**

29.1.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 15.2.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосноос хойш 60 хоногт багтаан түүнийг эзэмшигчтэй орд ашиглах гэрээ байгуулна.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

29.2.Орд ашиглах гэрээний хугацаа тусгай зөвшөөрлийн хугацаатай адил байна.

29.3.Орд ашиглах гэрээнд дараахь зүйлийг заавал тусгана:

29.3.1.цацраг идэвхт ашигт малтмалын орд ашиглах үндэслэл;

29.3.2.цацраг идэвхт ашигт малтмалын орд ашиглах хугацаа, цацраг идэвхт ашигт малтмалын нэр төрөл, агуулга, нөөцийн хэмжээ;

29.3.3.техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан технологи, үйлдвэрлэлийн хүчин чадал, олборлох бүтээгдэхүүний тоо хэмжээ;

29.3.4.бүтээгдэхүүн борлуулах нөхцөл;

29.3.5.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх зардлын хэмжээ;

29.3.6.уурхайг хаах ерөнхий төлөвлөгөө;

29.3.7.гэрээний талуудын эрх, үүрэг, хариуцлага.

29.4.Энэ хуулийн 29.1-д заасан хугацаанд орд ашиглах гэрээг байгуулаагүй бол геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

### **30 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын гэрээ**

30.1.Энэ хуулийн 15.1.2, 15.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хөрөнгө оруулагч өөрөө хүсэлт гаргавал үйл ажиллагаа явуулах нөхцөлийг нь тодорхой хугацаанд тогтвортой байлгах зорилгоор түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээг 10 хүртэл жилийн хугацаатай байгуулж болох бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

30.1.1.татварын орчныг тогтвортой байлгах;

30.1.2.тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлийн үнээр борлуулах;

30.1.3.олсон орлогоо захиран зарцуулах эрхийг нь баталгаажуулах;

30.1.4.хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаа;

30.1.5.ашигт малтмалыг хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хохирол багатай олборлох;

30.1.6.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх;

30.1.7.бусад төрлийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;

30.1.8.бүс нутгийг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгох;

30.1.9.учирсан хохирлыг нөхөн төлөх.

*/Энэ хэсгийг 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

30.2.Энэ хуулийн 30.1-д заасан гэрээг 10 хүртэл жилийн хугацаагаар сунгаж болно.

30.3.Энэ хуулийн 30.1-д заасан гэрээг хөрөнгө оруулагчтай Засгийн газар байгуулахдаа Улсын Их Хурлын аюулгүй байдлын асуудал эрхэлсэн Байнгын хороотой зөвшилцөнө.

*/Энэ хэсэгт 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

### **31 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах**

31.1.Хөрөнгө оруулагч нь энэ хуулийн 30.1-д заасан гэрээ байгуулах хүсэлт, гэрээний төслийг Цөмийн энергийн комисст ирүүлэх бөгөөд түүнд эхний 5 жилд оруулах хөрөнгийн хэмжээ, хугацаа, үйлдвэрийн хүчин чадал, бүтээгдэхүүний нэр төрөл, орд ашиглах арга, технологийн талаархи мэдээлэл, эдийн засгийн үндэслэлийг хавсаргана.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

31.2.Энэ хуулийн 15.1.3, 15.1.4, 15.2.2, 15.2.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд гэрээ байгуулах хүсэлт, гэрээний төсөлд мөн хуулийн 31.1-д заасан зүйлээс гадна тухайн ордын нөөцийг улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн тухай Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийг хавсаргана.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

31.3.Цөмийн энергийн комисс нь хөрөнгө оруулагчийн хүсэлт, гэрээний төсөл, хавсаргасан баримт бичгийг энэ хуулийн 31.1-д заасны дагуу хянаж, шаардлага хангасан тохиолдолд хүсэлт гаргасан этгээдэд 14 хоногт багтаан бичгээр мэдэгдэнэ.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

31.4.Цөмийн энергийн комисс нь хөрөнгө оруулагчийн хүсэлт, гэрээний төсөл, хавсаргасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 3 сарын дотор хянах бөгөөд шаардлагатай тохиолдолд зохих байгууллага, мэргэжилтний санал, дүгнэлтийг үндэслэн дахин 3 сар хүртэлх хугацаагаар нэмэлт тодруулга хийсний үндсэн дээр хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулна.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

31.5.Энэ хуулийн 30.1-т заасны дагуу хөрөнгө оруулалтын гэрээг байгуулсны дараа Цөмийн энергийн комисс уг гэрээний нөхцөлийн тухай мэдэгдлийг Монголбанк болон холбогдох бусад байгууллагад хүргүүлнэ.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

## **ТАВДУГААР БҮЛЭГ ЦӨМИЙН БОЛОН ЦАЦРАГЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ТАВИХ ШААРДЛАГА**

### **32 дугаар зүйл.Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах**

32.1.Цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглах, ашиглалтаас гаргах, цөмийн материалыг тээвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагааг биет хамгаалалтгүйгээр эрхлэхийг хориглоно.

32.2.Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах үйл

ажиллагааны биет хамгаалалтад мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, улсын байцаагч хяналт тавьж, үнэлгээ хийнэ.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

32.3.Цацрагийн аюулгүй байдлыг хангахад дараахь үндсэн шаардлагыг биелүүлнэ:

32.3.1.үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх;

32.3.2.шарлагын тунг зохистой хэмжээний хамгийн доод түвшинд байлгах;

32.3.3.хүн ам, үүний дотор цацрагтай ажиллагчийг шарлагын тунгийн тогтоосон хязгаараас илүүгээр өртүүлэхгүй байх.

### **33 дугаар зүйл.Цөмийн материал ашиглахад тавих үндсэн шаардлага**

33.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт зэвсгийн зориулалттай цөмийн материалыг боловсруулах, үйлдвэрлэх, бусад аргаар олж авах, эзэмших, хадгалахыг хориглоно.

33.2.Зэвсгийн зориулалттай цөмийн материалыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэхийг хориглоно.

33.3.Цөмийн энергийн комисс цөмийн материалыг бүртгэх, хянах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, хэрэгжилтэнд хяналт тавина.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

33.4.Цөмийн материалыг бүртгэх, хянах журмыг Засгийн газар батална.

### **34 дүгээр зүйл.Цацраг идэвхт ашигт малтмал ашиглахад тавих үндсэн шаардлага**

34.1.Улсын ерөнхий байцаагчийн зөвшөөрөлгүйгээр цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах, экспортлох, импортлох, тээвэрлэх, цацраг идэвхт хаягдлыг булшлах, цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээхийг хориглоно.

34.2.Энэ хуулийн 34.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх явцад хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс хамгаалах арга хэмжээг уг үйл ажиллагааг эрхэлж байгаа иргэн, компани өөрийн зардлаар хэрэгжүүлнэ.

### **35 дугаар зүйл.Цөмийн эрчим хүчний эх үүсвэр ашиглахад тавих үндсэн шаардлага**

35.1.Цөмийн эрчим хүчийг энэ хуулийн 35.2-т заасны дагуу баталгаажуулсан хэмжих багажгүйгээр үйлдвэрлэхийг хориглоно.

35.2.Энэ хуулийн 15.1.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч мөн хуулийн 35.1-д заасан хэмжих багажийг жил бүр стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар баталгаажуулна.

35.3.Энэ хуулийн 15.1.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сар бүрийн 10-ны дотор өмнөх сард үйлдвэрлэсэн цөмийн эрчим хүчний хэмжээг Цөмийн энергийн комисст мэдээлнэ.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

### **36 дугаар зүйл. Цацрагийн үүсгүүр ашиглахад тавих үндсэн шаардлага**

36.1.Цацрагийн үүсгүүрийг ашиглахад дараахь шаардлагыг биелүүлнэ:

36.1.1.цацрагийн үүсгүүрийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор цацрагийн хяналтын болон тагнуулын төв байгууллагад мэдэгдэж бүртгүүлэх;

36.1.2.цацрагтай холбогдсон үйл ажиллагааг цацрагийн аюулгүйн стандартыг бүрэн хангасан, улсын байцаагчийн зөвшөөрсөн зориулалтын байранд явуулах;

36.1.3.цацрагийн үүсгүүр ашиглах явцад ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангаж ажиллах;

36.1.4.цацрагтай холбогдсон үйл ажиллагааны онцлогт тохирсон цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм, цацрагийн хамгаалалтын хөтөлбөр, цацрагийн ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг улсын байцагчаар хянуулж, баталгаажуулан мөрдөх;

36.1.5.цацрагийн үүсгүүрийн ашиглалтын бүртгэл хөтөлж, жилийн эцсийн тооллогын дүн, дотоод хяналтын тайлан, мэдээг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

36.1.6.цацрагийн үүсгүүр ашиглах явцад гарсан осол, зөрчлийг цацрагийн хяналт, онцгой байдал, тагнуул, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдээлэх, ослын хор уршгийг арилгах, аюулгүй болгох арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх;

36.1.7.цацрагтай ажиллагчийг төрийн захиргааны байгууллагын зөвшөөрсөн тусгай хөтөлбөрийн дагуу явагдах цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын сургалтад хамруулж, гэрчилгээ олгох;

36.1.8.чанарын баталгаажилтын болон хэмжилтийн шаардлага хангасан цацрагийн хэмжилтийн багажаар хангагдсан байх.

36.2.Нэр төрөл, шинж чанар, идэвхийн хэмжээ, хэрэглэх зориулалт, аргачлал нь тодорхой бус цацрагийн үүсгүүрийг ашиглахыг хориглоно.

### **37 дугаар зүйл.Цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг экспортлох, импортлоход тавих үндсэн шаардлага**

37.1.Цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг экспортлоход дараахь шаардлагыг биелүүлнэ:

37.1.1.шилжүүлж байгаа цөмийн материалыг олон улсын баталгаанд хамруулсан байх;

37.1.2.хүлээн авч байгаа улс нь өөрийн ашиглаж байгаа бүх цөмийн материал, цөмийн төхөөрөмжийг олон улсын баталгаанд хамруулсан байх;

37.1.3.өмнө нь шилжүүлэн авсан цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг 3 дахь улсад шилжүүлэхийн өмнө Цөмийн энергийн комисст мэдэгдэж зөвшөөрөл авах;

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

37.1.4.цөмийн материалын биет хамгаалалт нь Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай Венийн конвенцид заасан шаардлагыг хангасан байх;

37.1.5.цөмийн материалыг хүлээн авч байгаа улс нь түүнийг зөвхөн энхийн зорилгоор ашиглах тухай нотолгоо ирүүлсэн байх;

37.1.6.цөмийн материалыг хүлээн авах эцсийн хэрэглэгчийн талаархи мэдээлэл, энхийн зорилгоор ашиглах тухай холбогдох нотолгоо, мэдээллийг Цөмийн энергийн комисст ирүүлсэн байх.

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

37.2.Цөмийн материал, цацрагийн үүсгүүрийг импортлоход дараахь шаардлагыг биелүүлнэ:

37.2.1.Монгол Улсын хуулиар хориглосон цөмийн материал, цацрагийн үүсгүүр, тоног төхөөрөмж, технологийг импортлохгүй байх;

37.2.2.цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг импортлогч нь Монгол Улсын хууль тогтоомжийн шаардлагыг бүрэн хангасан, холбогдох эрх бүхий байгууллагаас зохих хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөлтэй байх;

37.2.3.импортлож байгаа цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийн эцсийн хэрэглэгч нь тухайн материалыг аюулгүй ашиглах удирдлагын болон техникийн чадавхитай, хангалттай нөөц бололцоотойгоо нотолсон мэдээллийг Цөмийн энергийн комисст ирүүлсэн байх.

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

### **38 дугаар зүйл.Цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг хадгалахад тавих үндсэн шаардлага**

38.1.Цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг тусгай зөвшөөрөлд заасан зориулалтын хадгалах байранд хадгална.

38.2.Эзэнгүй буюу хаягдсан, олдмол цацраг идэвхт материалыг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэр, хяналтын дор энэ хуулийн 11.2-т заасан тусгай байгууламжид үнэ төлбөргүй шилжүүлнэ.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

38.3.Технологийн болон аюулгүй ажиллагааны шаардлага хангахгүй болсон, эсхүл ашиглагдахгүй байгаа цацрагийн үүсгүүрийг энэ хуулийн 11.2-т заасан тусгай байгууламжид хадгалуулна.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

### **39 дүгээр зүйл.Цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг тээвэрлэхэд тавих үндсэн шаардлага**

39.1.Цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг тээвэрлэхдээ цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх журмыг мөрдөнө.

39.2.Цөмийн материал болон цацрагийн үүсгүүр, цацрагийн үүсгүүртэй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн улс хоорондын тээврийг олон улсын холбогдох гэрээ, хэлэлцээр, дүрмийн шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

39.3.Цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх журмыг Засгийн газар батална.

### **40 дүгээр зүйл.Цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг худалдах, худалдан авахад тавих үндсэн шаардлага**

40.1.Цөмийн материалыг энэ хуулийн 15.1.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгээс бусад этгээд худалдах, худалдан авахыг хориглоно.

40.2.Цацрагийн үүсгүүр, цацрагийн үүсгүүртэй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг энэ хуулийн 15.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгээс бусад этгээд худалдах, худалдан авахыг хориглоно.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

#### **41 дүгээр зүйл.Цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих үндсэн шаардлага**

41.1.Цөмийн материалыг энэ хуулийн 15.1.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгээс бусад этгээд улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

41.2.Цацрагийн үүсгүүр, цацрагийн үүсгүүртэй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг энэ хуулийн 15.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгээс бусад этгээд улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

#### **42 дугаар зүйл.Цөмийн болон цацраг идэвхт материалыг хаягдал болгох, устгах, булшлахад тавих үндсэн шаардлага**

42.1.Цөмийн болон цацраг идэвхт материалыг хаягдал болгох, устгах, булшлахад олон улсын болон үндэсний стандарт, дүрэм, журмыг мөрдөнө.

42.2.Цөмийн болон цацраг идэвхт материалыг улсын байцаагчийн дүгнэлт, тусгай зөвшөөрөлгүйгээр булшлах, хаягдал болгохыг хориглоно.

42.3.Цацраг идэвхт хаягдлыг устгах, булшлахад дараахь үндсэн шаардлагыг биелүүлнэ:

42.3.1.цацраг идэвхт хаягдлыг устгах, булшлахад олон улсын болон үндэсний стандарт, дүрэм, журмыг чанд мөрдөх;

42.3.2.цацраг идэвхт хаягдлыг устгах, булшлах ажлыг холбогдох эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрлөөр улсын байцаагчийн хяналтын дор гүйцэтгэх.

42.4.Цөмийн төхөөрөмж, цацрагтай холбогдолтой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын аюулгүй ажиллагааны дүрмийг Засгийн газар батална.

#### **43 дугаар зүйл.Мэргэжлийн шарлагад тавих үндсэн шаардлага**

43.1.Цацрагтай ажиллагч нь мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтанд хамрагдана.

43.2.Мэргэжлийн шарлагын хяналтыг гүйцэтгэж байгаа байгууллага нь хувийн тунгийн нэгдсэн бүртгэлийг архивт 50 жил хадгална.

43.3.Цацрагтай ажиллагчийг цацрагийн аюулгүйн стандартад заасан шарлагын тунгийн хязгаараас илүүгээр өртүүлэхийг хориглоно.

43.4.Цацрагтай ажиллагч нь цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын шаардлага, хөдөлмөрийн хэвийн нөхцөлийг хангах асуудлаар байгууллагын захиргаанд шаардлага тавих, ажиллахаас татгалзах, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гомдлоо гаргах эрхтэй.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

43.5.Цацрагтай ажиллагч нь мэргэжлээс шалтгаалах өвчний эмнэлгийн тогтмол хяналтанд байж, эмнэлгийн үйлчилгээнд хамрагдана.

43.6.Шаардлагатай бол цацрагтай ажилладаг жирэмсэн эмэгтэй Хөдөлмөрийн тухай хуулийн 107 дугаар зүйлд заасны дагуу ажлын нөхцөлөө өөрчлөх эрхтэй бөгөөд энэ нь түүнийг ажлаас халах үндэслэл болохгүй.

43.7.Цацрагтай холбогдсон ажилд 18 насанд хүрээгүй хүнийг авч ажиллуулахыг хориглоно.

43.8.Мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтад хамрагдаж байгаа цацрагтай ажиллагчийн ажлын нөхцөл нь хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд хамаарна.

#### **44 дүгээр зүйл. Эмнэлгийн шарлагад тавих үндсэн шаардлага**

44.1.Эмнэлгийн шарлага хийхэд дараахь шаардлагыг биелүүлнэ:

44.1.1.цацрагийн үүсгүүрээр оношлогоо, эмчилгээ хийхдээ энэ хууль, цацрагийн аюулгүйн стандарт болон бусад холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажиллах;

44.1.2.цацрагийн үүсгүүрээр оношлогоо, эмчилгээ хийж байгаа этгээд нь ашиглаж байгаа багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжид тохируулга, чанарын хяналтыг тогтмол хийж байх;

44.1.3.хүүхдэд цацрагийн үүсгүүрээр оношлогоо, эмчилгээ хийхдээ түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлийг авсан байх;

44.1.4.эмчилгээ, оношлогооны үед өвчтөнийг цацрагийн аюулгүйн стандартад заасан тунгийн хязгаараас илүү шарлагад өртүүлэхийг хориглох;

44.1.5.эмчилгээ, оношлогооны үед өвчтөний биеийн бусад хэсгийг шарлагаас хамгаалах, өвчтөний асран хамгаалагч болон туслах ажилтныг хувийн хамгаалах хэрэгслээр хангах;

44.1.6.цацрагийн эмчилгээ, оношлогооны үед бусад өвчтөнийг шаардлагагүй нэмэгдэл шарлагад өртүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх.

### **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ЦӨМИЙН БОЛОН ЦАЦРАГИЙН ОСЛООС СЭРГИЙЛЭХ, ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ**

#### **45 дугаар зүйл.Цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх**

45.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цөмийн болон цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын хор уршгийг арилгах, аюулгүй болгох арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөртэй байх бөгөөд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцна.

45.2.Цөмийн болон цацрагийн ослын шалтгаан, түвшнийг тогтоох, ослын хор уршгийг арилгах ажлыг Улсын байнгын онцгой комисс холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

45.3.Нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн ослын хор уршгийг арилгах ажлын зардлыг Засгийн газар хариуцна.

*46 дугаар зүйл.Цөмийн болон цацрагийн ослын улмаас үүссэн хохирлыг арилгах*

46.1.Цөмийн энергийн тухай хууль тогтоомжийг зөрчсөний улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хохирол учруулсан бол уг хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

46.2.Энэ хуулийн 46.1-д заасан тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 30 жилийн хугацаанд дахин тусгай зөвшөөрөл олгохгүй.

### **ДОЛДУГААР БҮЛЭГ ОЛОН УЛСЫН БАТАЛГАА БОЛОН ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ**

#### **47 дугаар зүйл.Олон улсын баталгаа хэрэглэх**

47.1.Энэ хуулийн 15.1.1-15.1.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олон улсын баталгаа хэрэглэх асуудлаар Олон улсын атомын энергийн агентлагтай дараахь чиглэлээр хамтран ажиллана:

47.1.1.энэ хуулийн 28.8-д заасны дагуу цөмийн материалын тоо, хэмжээ, түүнд орсон өөрчлөлт, алдагдал, хорогдол, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой мэдээллийг Цөмийн энергийн комиссоор дамжуулан тогтоосон хугацаанд хүргүүлэх;

*/Энэ заалтад 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

47.1.2.баталгааны гэрээний дагуу Олон улсын атомын энергийн агентлагийн шинжээч, байцаагчийн хяналт шалгалтын ажилд дэмжлэг, туслалцаа үзүүлж, хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хууль зөрчсөн үйл ажиллагааг зогсоох талаар тавьсан шаардлагыг биелүүлэх.

#### **48 дугаар зүйл.Цөмийн энергийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих мэргэжлийн хяналт**

48.1.Цөмийн энергийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих мэргэжлийн хяналтыг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эрх бүхий улсын байцаагч хэрэгжүүлнэ.

*/Энэ хэсэгт 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

#### **49 дүгээр зүйл.Цөмийн энергийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих олон нийтийн хяналт**

49.1.Цөмийнэнергийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих олон нийтийн хяналтыг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд иргэн, хуулийн этгээд хэрэгжүүлнэ.

### **НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

#### **50 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

50.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

50.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

*/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

#### **51 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

51.1.Энэ хуулийг 2009 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**